



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 03

Мандалговь

Г

7

Г.Найгалмааг удирдах ажилтны  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 1 дүгээр хуралдааны шийдвэр, Адаацаг, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Сайнцагаан сумын “Хүмүүнлэг”, “Цэгцбилэг” сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Гурвансайхан сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Гэрэлтийн Найгалмаа 72.5 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Найгалмаагийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

